

ТӨСӨЛ
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
Сайдын 2020 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт

ГОЙД АШИГ ШИМТ МАЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Гойд ашиг шимт малын шалгаруулах журмын зорилго нь удам гарваль, ашиг шим, галбир, бие цогцос үр төлийн чанараар гойд ашиг шимт малаар шалгарсан мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтныг олон нийтэд сурталчлан таниулах, хойч үедээ өвлүүлж үлдээх, малчид үйлдвэрлэгчдийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, урамшуулахад оршино.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үржлийн гойд ашиг шимт малын үзэсгэлэн, дуудлага худалдаа зохион байгуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдааны зорилго нь ашиг шимийн гарц, чанар, удам зүйн үнэлгээ, эрүүл мэндээр баталгаажсан шилмэл малыг мал үржүүлэгчдэд таниулж, үр төлийг олшруулах, шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгчийг аж ахуйн нэгж, иргэдэд худалдаж мал сүргийн чанарыг сайжруулахад оршино.

1.3. Монгол улсад үржүүлж буй хянан баталгаажсан үүлдэр, омгийн мал болон өндөр ашиг шимт импортын мал, тэжээвэр гойд ашиг шимт малаар сонгон шалгаруулахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн, дуудлага худалдаа зохион байгуулах

2.1. Гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдааг улсын хэмжээнд жил бүр, бүсийн хэмжээнд 3 жил тутам 1 удаа Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн зохион байгуулна.

2.2. Үржлийн малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдааг аймаг, нийслэлд жил тутамд зохион байгуулах бөгөөд явуулах хугацааг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

2.3. Гойд ашиг шимт малын шалгаруулах үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тухайн аймаг, сумын засаг дарга, улсын хэмжээнд Улсын хэмжээнд гойд ашиг шимт мал шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

2.4. Гойд ашиг шимт үржлийн малын үзэсгэлэн, худалдааг улсын хэмжээнд сум бүрээр зохион байгуулах, бэлтгэлийг хангуулах, мэргэжлийн арга зүйн туслалцаа үзүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж мал үржүүлэгчдэд мэдээлэх ажлыг аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар хариуцан хэрэгжүүлнэ.

2.5. Гойд ашиг шимт малыг гарвал, ашиг шимийн гарц, чанар бие цогцос, эрүүл мэндийн үзүүлэлтийг харгалзан бүх шатанд итгэмжлэл, зэрэг дэв бүхий мэргэжлийн шинжээч, шүүгчид шалгаруулна.

2.6. Шалгарсан гойд ашиг шимт шилмэл малыг улсын үржлийн дэвтэрт бүртгэж, гэрчилгээ олгоно.

2.7. Мал үржүүлэгчид нь Үзэсгэлэн худалдаанд оролцох малын тоо, ашиг шимийн гол үзүүлэлт, багцлал, дуудах анхны үнэ зэргийг багтаасан мэдүүлгийг Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсэгт арга хэмжээ зохион байгуулагдах өдрөөс 7 хоногийн дотор ирүүлнэ.

2.8. Гойд ашиг шимт шилмэл мал шалгаруулах тов, байршлыг зохион байгуулах ажлын хэсэг 15-аас доошгүй хоногийн өмнө зарлан мэдээлнэ.

Гурав. Гойд ашиг шимт малын шалгаруулах үзэсгэлэн худалдаанд оролцуулах малд тавигдах шаардлага

3.1. Гойд ашиг шимт малын шалгаруулах үзэсгэлэн худалдаанд ашиг шимийн бүх чиглэлийн мал, тэжээвэр амьтныг оролцуулах ба

- Суманд /дүүрэг/ шалгарсан гойд ашиг шимт мал, амьтан тэдгээрийн төл нь аймаг, нийслэлийн;

- Аймагт /нийслэл/ шалгарсан мал гойд ашиг шимт мал нь улс, бүсийн гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн худалдаанд оролцох эрхтэй.

3.2. Хувийн дугаартай, гарвал, ашиг шим нь Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн, удам зүйн үнэлгээний программаар үнэлгээ хийгдсэн байх;

3.3. Ажил эдэлгээнд сургагдсан, гаж буруу зан авиргүй дундаас тээш тарга хүчтэй, эрүүл байх;

3.4. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдаж, эрүүл болохыг мэргэжлийн байгууллага тогтоосон байх;

3.4. Ашиг шимийн дундаж үзүүлэлт нь тухайн үүлдэр, омгийн малын шилмэл ангийн шаардлагыг хангасан байх;

Дөрөв. Гойд ашиг шимт малын шалгаруулах үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зардал

4.1. Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь хэсэгт заасны дагуу сум, дүүрэг, аймагт шалгарсан гойд ашиг шимт малын эзэн, уг малыг илрүүлэн шалгаруулсан мэргэжилтэн нарт олгох шагналын хэмжээ, гойд ашиг шимт малын тэжээл маллагаа, зохион байгуулахтай холбогдох зардлыг тухайн шатны Засаг дарга, улсын хэмжээнд Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, шаардагдах зардал, хөрөнгийг шийдвэрлэнэ.

4.2. Шилдэг оролцогч аймаг, иргэн, ААН, түнш, тэжээвэр амьтныг шалгаруулж урамшуулал олгоно. Урамшууллыг тууз, зүүлт, өргөмжлөл, диплом дагалдана.

4.3. Гойд ашиг шимт мал, амьтныг дараах номинациудаар шалгаруулж, урамшуулна.

	Мал, амьтны төрөл	Ашиг шимийн чиглэл	Номинацууд	Тэргүүн байр	Дэд байр	Тусгай байр
1.	Адуу	Уналга, хурд	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	2
		Мах	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	2
2.	Тэмээ		Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	2
3.	Үхэр	Мах	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	2

		Сүү	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	2
		Хосолмол	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	2
4.	Импортын үхэр	Махны	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	1	1
		Сүүний	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	1	1
5.	Хонь	Нарийн нарийвтар ноост	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	2
		Ширүүн ширүүвтэр ноост	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	2
		Мах	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	1
6.	Ямаа	Ноолуурын	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	2
		Сүүний	Хээлтэгч, хээлтүүлэгч	2	1	1
7.	Сарлаг		Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	1
8.	Гахай		Хээлтэгч, хээлтүүлэгч	2	2	1
9.	Шувуу, жижиг амьтан			1	1	1
10.	Шилдэг оролцогч аймаг, иргэн, ААН, мэргэжилтэн			3	3	3

.....о О о.....